



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 44

Мандалговь

Орон нутгийн өмчөөс Төрийн өмчид
хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 6,396,666 /зургаан сая гурван зуун ерэн зургаан мянга зургаан зуун жаран зургаа/ төгрөгийн балансын үнэтэй, 1,018,749.78 /нэг сая арван найман мянга долоон зуун дөчин есөн төгрөг далан найман мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан хөрөнгийг Дундговь аймгийн Соёл урлагийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Адъяасүрэн), Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Соёл урлагийн газарт хөрөнгө шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
77 дугаар тогтоолын хавсралт

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн Соёл урлагын газарт балансаас балансад
шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1.	HP ProDesk 400 G7 /процессор/ Windows10Pro 64-bit Core (TM) i5	2021.12.21	ш	2	2,408,333	4,816,666	722,499.84	4,094,166.16
2.	HP P24v G4 FHD Компьютерийн дэлгэц	2021.12.21	ш	2	790,000	1,580,000	296,249.94	1,283,750.06
Нийт								
						6,396,666	1,018,749.78	5,377,916.22
						/зургаан сая гурван ерэн мянга зуун зургаан зуун жаран зургаа/ төгрөг	/нэг сая арван найман мянга долоон зуун дөчин төгрөг найман мөнгө/ төгрөг	/таван сая гурван зуун далан долоон мянга есөн зуун арван зургаан төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөг